



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаартай “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.11, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2024/18-11-ШТА-ГА) тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, дүнг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэхийг Дүүргүүдийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002010317



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөх, ХАА зохион байгуулах, гүйцэтгүүлэх, шат шатны хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг бүрэн мөрдөөгүйгээс өмнөх жилүүдэд гарсан зөрчлүүд дахин давтагдаж байна.



АУДИТЫН СЭДЭВ: ДҮҮРГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Улаанбаатар хот
2024 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	2
Нийслэл дэх Төрийн аудитын газар	Хүснэгтийн жагсаалт	3
Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтэс	Хавсралтын жагсаалт	3
Хэлтсийн дарга Э.Мөнхмандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4
Аудитын менежер:	Ерөнхий мэдээлэл	5
 Л.Саранбаатар	А.1 Төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх	6
Аудитор:	А.1.1. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн үү?	6-11
 С.Анужин	Б.2 Төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хуульд нийцүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх	12
 М.Одгэрэл	Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	12-17
 О.Оргил	Б.2.2. Захиалагч нь төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?	18-25
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө "Г" корпус, Утас: 11-327787	В.3 Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу?	26
Тайланг НТАГ-ын http://www.audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	В.3.1. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд авсан уу?	26-28
	В.3.2 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?	29-30
	Аудитын дүгнэлт	31
	Аудитын зөвлөмж	32
	Холбогдох байгууллагын санал	33-35
	Саналд өгсөн тайлбар	36
	Хавсралтууд	37-48

Товчилсон үг

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ДАА	Дотоод аудитын алба
ДИТХ	Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ДЗД	Дүүргийн Засаг дарга
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НД	Налайх дүүрэг
НЗХГ	Нийслэлийн замын хөгжлийн газар
НХААГ	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн Аудитын газар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТГҮХ	Төлөвлөлт, гүйцэтгэл удирдлагын хэлтэс
ТНААХ	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШХА	Шууд худалдан авалт

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	2022, 2023 онд хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний харьцуулалт	5
Хүснэгт 2	Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал	7
Хүснэгт 3	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдаагүй ТАХ-ний тоо	8
Хүснэгт 4	Холбогдох зардлын тооцоолол хийх шаардлагатай ТАХ	8
Хүснэгт 5	Дүүргийн 2023 оны төсвийн төсөлд иргэдээс ирүүлсэн санал	9
Хүснэгт 6	Дүүргийн 2023 оны ТАХ-ний ангилал	10
Хүснэгт 7	Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ	11
Хүснэгт 8	Газрын зөвшөөрөлгүй ТАХ	11
Хүснэгт 9	Төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн ТАХ	12
Хүснэгт 10	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ	13
Хүснэгт 11	ХАА зохион байгуулаагүй ТАХ	13
Хүснэгт 12	ТАХ задарсан байдал	15
Хүснэгт 13	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам	15
Хүснэгт 14	ХАА-ны зөрчил	15
Хүснэгт 15	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага	19
Хүснэгт 16	2023 онд хэрэгжсэн, он дамжсан, хэрэгжээгүй ТАХ	20
Хүснэгт 17	ТАХ-ний санхүүжилтийн судалгаа	25
Хүснэгт 18	2023 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги	25
Хүснэгт 19	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан ТАХ-ний жагсаалт	26
Хүснэгт 20	Хэрэгжсэн ТАХ-ээс бүртгэлд тусгасан байдал	28
Хүснэгт 21	Дотоод аудитын албадаас хийхээр төлөвлөсөн хяналт, шалгалт	30

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгаагүй ТАХ	38-39
Хавсралт 2	ЗД-ын мөрийн хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй ТАХ	39-40
Хавсралт 3	Холбогдох зардлын тооцоолол хийх шаардлагатай ТАХ	40
Хавсралт 4	Зураг төсөв боловсруулаагүй батлуулсан ТАХ	41-44
Хавсралт 5	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4-дэх заалтыг зөрчсөн ТАХ	45-46
Хавсралт 6	ХАА удааширсан, үнэлгээний хороо байгуулснаас хойш ХАА-г 100-с дээш хоногт зарласан ТАХ-ний жагсаалт	46-47
Хавсралт 7	Зардлаар бүртгэсэн ТАХ-ын жагсаалт	47
Хавсралт 8	ТАХ-ний задарсан байдал	47-49

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудитын зорилт	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх сэдвийг үндэслэн хийв. Аудитын зорилт Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:  Хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх  Хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хуульд нийцүүлж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх  Хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг дүүргүүдийн ЗДТГ-ын СТСХ, ТГУХ, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Худалдан авах ажиллагааны албадыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын хэлтсийн дарга Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Саранбаатар хэрэгжүүлж, аудитор С.Анужин, М.Одгэрэл, О.Оргил нар гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2023 онд дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр нийт 324,669.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 624 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.

Үүнээс 195,816.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 438 ТАХ нь шинээр, 128,853.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 186 ТАХ өмнөх оноос дамжин хэрэгжиж буй ТАХ байна.

Дээрх ТАХ-ээс 136 буюу 21.8% нь барилга байгууламж, 218 буюу 34.9% нь тоног төхөөрөмж, 76 буюу 12.2% нь тохижилт, 60 буюу 9.6% нь их засвар, 57 буюу 9.1% нь зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, 18 буюу 2.9% нь авто зам дэд бүтэц, 59 буюу 9.5% нь бусад ажил байна.

Худалдан авалт: Дүүргүүдийн ЗД нар худалдан авах ажиллагааг зохион байгуулах захирамж гаргахдаа 438 ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 564 ТАХ болгон хуваажээ.

Үүнээс 2023 онд 169,796.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 475 ТАХ зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан, 26,298.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 78 ТАХ хэрэгжиж дуусаагүй үргэлжилж байгаа, 3,668.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ хэрэгжээгүй байна.

Гүйцэтгэл: Өмнөх оноос дамжсан болон 2023 онд шинээр эхэлсэн нийт 256,480.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 714 ТАХ-нд дүүргүүдийн ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс болон “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, “Сэтгэшгүй нэмэх” ХХК, “Сод си би ар инженеринг” ХХК, “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ, “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ зэрэг байгууллагууд захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

2023 онд 102,118.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 461 ТАХ хэрэгжиж дууссан, 150,953.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 157 ТАХ хэрэгжилт дутуу 2024 он дамжин хэрэгжиж байгаа, 3,408.2 сая төгрөгийн 96 ТАХ хэрэгжээгүй байна.

Санхүүжилт: Дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 624 ТАХ-нд 250,459.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 477 ТАХ 132,241.1 сая төгрөг буюу 52.8 хувийн санхүүжилтийг олгожээ.

Аудитын түүврийг хийхдээ МУЕА-ын 2018 оны А/351 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2023 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- **Төлөвлөлт:** 2023 онд шинээр төлөвлөсөн 195,816.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 438 ТАХ-ээг бүрэн хамруулсан;
- **Худалдан авалт** зохион байгуулсан 475 ТАХ-ээс 147,471.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 315 ТАХ буюу 66.3%-ийг хамруулсан;
- **Гэрээний хэрэгжилт:** 2023 онд бүрэн дууссан, санхүүжилт олгосон 150,953.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 461 ТАХ-ээс 39.0% буюу 180 ТАХ-г хамруулсан;
- **Санхүүжилт:** Шинээр болон он дамжин хэрэгжсэн 477 ТАХ-нд олгосон 132,241.1 сая төгрөгийн санхүүжилт, барьцаа хөрөнгө, хүү алданги торгууль, техникийн болон захиалагчийн хяналтын зардлыг 100% тулган баталгаажуулсан.

БҮЛЭГ А1. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН ЭСЭХ

А.1.1. Төсөл, арга хэмжээг Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн үү?

Дүүргүүдийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 195,816.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 438 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 2. Шинээр төлөвлөсөн ТАХ-г ангилсан байдал

№	Ангилал	Тоо	Төсөвт өртөг	(сая.төг)	
				Эзлэх хувь	
1	Барилга байгууламж	25	47,155.6	24.1%	
2	Авто зам, Дэд бүтэц	59	46,441.2	23.7%	
3	Засвар	66	29,808.9	15.2%	
4	Зураг төсөв	37	4,705.5	2.4%	
5	Тоног төхөөрөмж	169	22,614.3	11.5%	
6	Тохижилт	46	28,778.1	14.7%	
7	Бусад	36	16,312.4	8.3%	
	Нийт	438	195,816.0	100%	

Эдгээр ТАХ-ээс “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 388 ТАХ буюу 88.5% нь нийцсэн, 50 ТАХ буюу 11.5% нь нийцээгүй, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 421 ТАХ буюу 96.1% нь нийцсэн, 17 ТАХ буюу 3.9% нь тус тус нийцээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгах” шаардлагад нийцээгүй 85,976.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 133 ТАХ, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4-т заасан “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” шаардлагад нийцээгүй 12,844.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ТАХ-г 2023 оны төсөвт хэрэгжүүлэхээр тусгасан байна.

А.1.1.1 Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох зардлын тооцоолол хийж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцүүлсэн үү?

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн эсэх:

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 438 ТАХ-г хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- **Дунд хугацааны баримт бичиг:** “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 388 буюу 88.5% нь нийцсэн, 50 буюу 11.5% нь нийцээгүй, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т 421 буюу 96.1% нь нийцсэн, 17 буюу 3.9% нь нийцээгүй байна. Хавсралт 1, 2
- **Богино хугацааны баримт бичиг:** ДЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөөнд 421 буюу 96.1% ТАХ нь нийцсэн байна.

Хүснэгт 3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд тусгагдаагүй ТАХ-ний тоо

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан эсэх		ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тусгагдсан эсэх	
			Тусгасан	Тусгаагүй	Тусгасан	Тусгаагүй
1	БГД	129	125	4	128	1
2	БЗД	70	68	2	69	1
3	БНД	42	3	39	31	11
4	БХД	11	11	-	11	-
5	НД	33	33	-	33	-
6	СБД	37	37	-	37	-
7	СХД	23	19	4	21	2
8	ХУД	60	59	1	58	2
9	ЧД	33	33	-	33	-
	НИЙТ	438	388	50	421	17

Холбогдох зардлын тооцоолол хийсэн эсэх:

Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 4.1.6¹-д зааснаар ТАХ-г төлөвлөхдөө холбогдох зардлын тооцоолол хийсэн байх шаардлагатай.

Дүүргүүдийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 438 ТАХ-ээс барилга байгууламжтай холбоотой 26,075.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ-нд холбогдох зардлын тооцоолол хийгээгүй байна. Хавсралт 3

Хүснэгт 4. Холбогдох зардлын тооцоолол хийгээгүй ТАХ
(сая.төг)

№	ДҮҮРЭГ	Ангилал: Барилга байгууламж	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БГД	1	200.0
2	БЗД	5	5,275.2
3	БНД	1	177.8
4	БХД	-	-
5	НД	2	178.0
6	СБД	2	10,500.0
7	СХД	2	187.0
8	ХУД	3	2,957.0
9	ЧД	3	6,600.0
	НИЙТ	19	26,075.0

Зардлын тооцоолол хийгээгүйгээс шалтгаалж төсвийн хөрөнгө оруулалтаар бий болж ашиглалтад хүлээн авсан зарим хөрөнгүүд ашиглалтгүй байна. Тухайлбал:

- БГД-ийн “Салбар цэцэрлэг байгуулах ажил” (27 дугаар хороо). Гэрээний дүн: 193.0 сая төгрөг. Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын байрны 1-р давхарт байгуулсан салбар цэцэрлэг нь аль салбар цэцэрлэгт хамаарах нь тодорхойгүй, орон тоо, урсгал зардлын хэмжээг тооцсон тооцоололгүй, холбогдох зөвшөөрөл аваагүй зэрэг шалтгаанаар ашиглалтгүй байна.
- БЗД-т хэрэгжиж дууссан “Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг хөдөлмөрт сургах, хөдөө аж ахуй, монгол ахуйн чиглэлээр боловсрол, төлөвшлийг олгох зорилгоор хөдөлмөр зуслан худалдан авах ажил”. Гэрээний дүн: 1,200.0 сая төгрөг. Дээрх зусланг 2023 оны 7 сард комиссын актаар хүлээн авсан ч ашиглалтгүй байна. Үүнд: “Хичээлийн жилийн улиралтай зохицуулан зуны улиралд ажиллахаар хүлээгдэж байгаа” гэсэн тайлбарыг БЗД-ийн ЗДТГ-аас ирүүлсэн.

Дүгнэлт: 2023 онд шинээр хэрэгжих 438 ТАХ-ээс хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд дунджаар 92.3%-ийг нийцүүлсэн байна. Харин барилга байгууламжийн хөрөнгө ашиглалттай холбоотой зардлын тооцоолол хийгээгүй байна.

¹ 4.1.6. шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор нэмэгдэх орон тоо, урсгал зардлын хэмжээг тооцсон байх.

А.1.1.2 ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслэсэн үү?

Олон нийтийн саналд үндэслэсэн эсэх:

Дүүргүүд нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажилд иргэд олон нийтээс санал авах тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Харин иргэд олон нийтийн оролцоог хангах үүднээс Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2² дахь заалтын дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-нд санал авдаг байна.

2023 онд хэрэгжүүлэх ажлын санал авах арга хэмжээг дүүргүүд нь НЗД-ын 2022 оны 03 сарын 02-ны өдрийн А/301 дүгээр захирамжийн /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний саналыг цахим хэлбэрээр олон нийтээс авах ажиллагаа/ дагуу 2022 оны 4-р сарын 15-ны өдрөөс 06 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан байна.

Иргэдээс <https://onhs.mof.gov.mn/> цахим хуудсанд хөрөнгө оруулалттай холбоотой 145,299 санал ирүүлсэн байна.

Хүснэгт 5. Иргэдээс ирүүлсэн санал

					(сая.төг)
№	Иргэдийн санал	Саналын тоо	Эзлэх хувь	ТАХ-ний тоо	Эрэмбэлэгдсэн жагсаалт
1	Гудамж талбайн камержуулалд хийх	15,946	11.0%	7	7
2	Явган хүний зам, засвар шинэчлэл орчны тохижилт	13,944	9.6%	21	4
3	Орон сууцны байрны дээвэр засвар	10,777	7.4%	3	9
4	Тоглоомын талбайн засвар шинэчлэл, орчны тохижилт	1,549	1.0%	58	2
5	Орон сууцны фасад засвар	6,033	4.2%	28	3
6	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт	19,129	13.1%	5	8
7	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	13,946	9.6%	2	10
8	Авто зогсоол байгуулах	12,336	8.5%	19	5
9	Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай засвар, тохижилт	95	0.1%	12	6
10	Гэрэлтүүлэг болон бусад	51,544	35.5%	219	1
НИЙТ ДҮН		145,299	100%	374	

Дээрх 374 ТАХ-нд санал эрэмбэ дарааллыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзэхэд нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гудамж талбайн камержуулалд, явган хүний зам, засвар шинэчлэл орчны тохижилт, авто зогсоол, гэрэлтүүлэг, ногоон байгууламж байгуулах зэрэг ТАХ-г жагсаалтад тусгаж баталсан байна.

Эрэмбэ дарааллыг харгалзсан эсэх:

Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4³, 4.5⁴, 5 дугаар зүйлийн 5.10⁵-д заасны дагуу ТАХ-г эрэмбэлэхдээ өмнөх оноос хэрэгжсэн ТАХ, их засвар, шинээр хэрэгжүүлэх ТАХ гэсэн дарааллаар, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, тэргүүлэх чиглэлийн төслүүд байх гэсэн үзүүлэлтийг харгалздаг байна.

² 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

³ 4.4 Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална. Үүнд:..4.4.1 шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл

4.4.2 Их засварын төсөл

4.4.3 Шинээр хэрэгжүүлэх төсөл

⁴ 4.5 Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

⁵ 5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй;

Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжих 128,853.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 186 ТАХ, шинээр хэрэгжих 195,816.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 438 ТАХ, нийт 324,669.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 624 ТАХ-г эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор ангилж, барилга байгууламж, автозам, их засвар, тохижилт зэргээр эрэмбэлж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. Дүүргийн 2023 оны ТАХ-ний ангилал
ТАХ-НИЙ АНГИЛАЛ

№	ДҮҮРЭГ	ШИЛЖИХ ТАХ	ШИНЭ ТАХ	Барилга байгууламж	Авто зам, Дэд бүтэц	Их засвар	Зураг төсөв	Тоног төхөөрөмж	Тохижилт	Бусад	НИЙТ
1	БГД	Шилжих		0	0	0	2	0	2	0	4
			Шинэ	2	3	11	0	98	13	1	128
2	БЗД	Шилжих		2	15	4	4	5	9	0	39
			Шинэ	5	32	16	1	4	9	3	70
3	БНД	Шилжих		0	0	2	8	5	3	0	18
			Шинэ	1	4	3	10	23	1	0	42
4	БХД	Шилжих		0	0	0	2	0	0	0	2
			Шинэ	0	1	1	5	3	0	1	11
5	НД	Шилжих		0	0	0	2	0	0	0	2
			Шинэ	2	3	4	1	9	1	13	33
6	СБД	Шилжих		8	2	4	2	2	4	4	26
			Шинэ	5	2	12	1	1	6	10	37
7	СХД	Шилжих		3	2	2	1	2	1	2	11
			Шинэ	3	7	4	1	4	4	1	24
8	ХУД	Шилжих		9	3	4	16	2	2	1	37
			Шинэ	4	7	12	14	11	11	1	60
9	ЧД	Шилжих		5	2	2	7	4	1	26	47
			Шинэ	3	0	3	4	16	1	6	33
	Шилжих			27	24	16	44	20	22	33	186
	Шинэ			25	59	66	37	169	46	36	438
	НИЙТ			52	83	82	81	189	68	69	624

Дүгнэлт: Дүүргүүд нь 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г ач холбогдол, эрэмбэ, дарааллыг баримтлан олон нийтийн саналд үндэслэсэн байна.

А.1.1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгасан уу?

Төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангасны дараа төсөвт тусган баталж, хэрэгжүүлэхээр заажээ.

Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 195,816.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 438 ТАХ-г төлөвлөж баталсан.

Шинээр хэрэгжүүлэх 438 ТАХ-ээс 132,778.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 215 ТАХ буюу 49.1%-д нь зураг төсөв шаардлагатай байна. Үүнээс 105,901.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 133 ТАХ буюу 61.9% зураг төсөвгүй ТАХ байна.

Хавсралт 4

Хүснэгт 7. Зураг төсөв боловсруулаагүй ТАХ

№	Дүүргийн нэр	(сая.төг)			
		Зураг төсөв Тоо	шаардлагатай ТАХ Төсөвт өртөг	Үүнээс зураг төсөвгүй Тоо	Төсөвт өртөг
1	БГД	29	10,814.0	28	9,459.6
2	БЗД	56	56,129.6	55	55,429.6
3	БНД	8	1,803.3	1	415.4
4	БХД	2	110.0	2	110.0
5	НД	9	566.3	2	175.0
6	СБД	34	21,402.2	12	15,352.2
7	СХД	18	5,359.5	12	4,334.3
8	ХУД	49	29,758.3	17	15,191.5
9	ЧД	10	6,835.3	4	5,434.0
	Нийт	215	132,778.5	133	105,901.6

Шинээр хэрэгжих ТАХ-ээс 12 ТАХ-нд газрын зөвшөөрөл шаардлагатайгаас 5 ТАХ газрын зөвшөөрөлгүй байна.

Хүснэгт 8. Газрын зөвшөөрөлгүй ТАХ

(сая.төг)

Газрын зөвшөөрөл шаардагдах			Газрын зөвшөөрөлгүй		
ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
12	34,905.5	32,905.3	5	7,632.0	7,632.0

ТАХ-г төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г тусгаж, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁶ дэх заалтыг зөрчсөнөөс шалтгаалж тухайн онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжихгүй байх, он дамжих зэргээр ТАХ-ний эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг бууруулах үр дагавар үүсгэж байна. Тухайлбал:

- ХУД-т “Цэцэрлэгийн барилгын ажил”. Гэрээний дүн: 1,995.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Инерци ХХК. Тус ТАХ-г 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө газрын зөвшөөрөлгүй төлөвлөснөөс ХАА зохион байгуулах хугацаа хойшлон, гэрээг 2023.10.05-нд байгуулсан, хүйтний улирал эхэлсэн, үүнээс шалтгаалж тухайн онд хэрэгжих боломжгүй болж гэрээний хугацааг сунгасан байна.
- БЗД-т “Худгийн ажил” (11 дүгээр хороо). Гэрээний дүн: 123.4 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Урал-Их” ХХК. 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г газрын зөвшөөрөлгүй төлөвлөсөн мөн дээрх ТАХ-тэй адил нөхцөл үүсэж, технологийн зогсолт хийн дулааны улиралд ажлыг эхлүүлэхээр хойшлуулсан.
- БЗД-т “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн (Ай Жи Эм)”-ийн цахилгаан хангамжийн ажил (28 дугаар хороо). Гэрээний дүн: 940.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Эйч ар ви констракшн ХХК. Цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан ч ерөнхий төлөвлөгөө нь батлагдаагүйн улмаас ажил удааширсан.
- СХД-т “Усан сан барих ажил” (33 дугаар хороо). Гэрээний дүн: 79.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жигүүрт хөсөг ХХК. Анх тендер зарлахдаа нэг маягийн зургаар зарласан бөгөөд дахин зураг төсөв магадлалаар оруулахад зураг, төсөвт өөрчлөлт орсон тул ажил удааширсан.
- БНД-т “70-74 байрны зүүн талд авто зам дагуух тохижилт”. Гэрээний дүн: 175.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Багануур АЗЗА ТӨХК. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй шугам сүлжээний ажлаас шалтгаалан хүлээгдэж байна.
- ЧД-т “Хорооны цогцолбор барилга барих”. Гэрээний дүн: 2,480.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Рок гранд ХХК. 2023.10.18-нд гэрээ байгуулсан. Хүйтний улирал эхэлсэн, үүнээс шалтгаалж тухайн онд хэрэгжих боломжгүй болж гэрээний хугацааг сунгасан байна.

Цаашид Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төсөвт тусган батлахгүй байх талаарх албан шаардлагыг дүүргүүдэд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: ТАХ-г төлөвлөхдөө техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдоогүй төсөл, арга хэмжээг тусгасан нь ТАХ-ний гүйцэтгэл удааширах, хэрэгжихгүй болох нөхцөл үүсгэж байна.

⁶ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

А.1.1.4 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсэн үү?

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулахгүй байхаар заасан байна.

Гэтэл 2023 онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн 12,844.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 ТАХ-ний гэрээг БЗД, ЧД, СХД, БНД, ХУД-үүд 2023.10 дугаар сараас хойш байгуулсан байна. Хавсралт 5

Хүснэгт 9. Төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн ТАХ

(сая.төг)					
д/д	Дүүрэг	Тах-ний тоо	Төсөвт өртөг	Эхлэх он	Дуусах он
1	БЗД	3	1,010.0	2023	2023
2	БНД	3	516.2	2023	2023
3	СХД	1	210.0	2023	2023
4	ХУД	18	7,053.1	2023	2023
5	ЧД	8	4,055.0	2023	2023
НИЙТ		33	12,844.3		

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

БҮЛЭГ Б.2. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЖ, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ

Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

Дүүргүүдийн ИТХ-ын Төсөв батлах тухай тогтоолуудаар 2023 онд 195,816.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 438 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталсан.

Дүүргүүдийн ЗД нар худалдан авах ажиллагааг зохион байгуулах захирамж гаргахдаа 438 ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 564 ТАХ болгон хуваажээ. Үүнээс 2023 онд 169,796.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 475 ХАА зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 10. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ

№	Дүүргийн нэр	ХАА зохион байгуулсан ТАХ		ХАА амжилттай зохион байгуулсан ТАХ			
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг	Шалгарсан өртөг	Хэмнэлт
1	БГД	128	14,953.0	115	9,102.6	8,488.9	613.7
2	БЗД	70	65,133.8	66	63,233.4	62,171.1	1,062.3
3	БНД	60	5,029.6	41	3,464.9	3,375.0	89.9
4	БХД	11	288.5	11	288.5	280.9	7.6
5	НД	33	1,151.3	30	943.3	931.3	12.0
6	СБД	72	43,633.0	68	42,125.3	41,805.7	319.6
7	СХД	69	12,223.4	57	7,809.7	5,875.6	1,934.0
8	ХУД	74	38,528.1	48	27,836.1	22,804.2	5,031.9
9	ЧД	47	18,822.7	39	14,992.4	14,491.9	500.5
	Нийт	564	199,763.4	475	169,796.2	160,224.6	9,571.5

Харин 26,298.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 78 ТАХ буюу 87.6%-ийн ТББ боловсруулах, үнэлгээ хийх зэргээр тухайн онд бүрэн дуусаагүй, 2024 он дамжин үргэлжилж байна.

3,668.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ буюу 12.4% нь үнэлгээний хороо байгуулагдсан ч зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүй, эх үүсвэр дутагдалтай төсөв хянуулахаар захиалагчид буцаасан болон бусад шалтгаанаар төсвийн тодотголоор хөрөнгө нь татагдаж, хэрэгжээгүй байна.

Хүснэгт 11. ХАА зохион байгуулаагүй ТАХ

№	Дүүргийн нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	(сая.төг)	
				Тайлбар	
1	БЗД	Сургуулийн байрыг спорт заалтай холбох ажил	100.0	хөрөнгө татагдсан	
2	БЗД	Гэр хорооллын бүсэд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил	700.0	хөрөнгө татагдсан	
3	БЗД	УС-15 хотхоны борооны ус зайлуулах шугам сүлжээний угсралтын ажил	500.5	хөрөнгө татагдсан	
4	БЗД	Сэлбэ, Улиастай голын үерийн далан орчмын тохижилтын ажил	599.8	хөрөнгө татагдсан	
5	ЧД	Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны ногоон бүсэд нэвтрэх орц, гарцыг сайжруулах	79.0	Тодотголоор хассан.	
6	ЧД	Дүүргийн бүтээн байгуулалтын ажлын зураг төсвүүд	106.2	ажлын даалгаваргүй ТАХ	
7	СБД	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Нэгдсэн эмнэлгийн материаллаг бааз бэхжүүлэх Багц3-Дуран оношилгоо	712.0	захиалагчид төсөв хянуулахаар хүргүүлсэн	
8	СБД	9-р хороо, Алтайн гудамжинд тохижилт, гэрэлтүүлэг хийх	200.0	захиалагчид төсөв хянуулахаар хүргүүлсэн	
9	СБД	Дүүргийн нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийх	513.0	захиалагчид төсөв хянуулахаар хүргүүлсэн	
10	СБД	Дүүргийн нутаг дэвсгэрт тохижилтын ажил хийх	82.7	эх үүсвэр дутагдалтай	
11	ХУД	Камерын нэгдсэн хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар тохижилт	75.1	Зураг төсөв, ажлын даалгавар ирүүлээгүй.	
		НИЙТ ДҮН	3,668.3		

Б. 2.1.1 Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хуульд нийцүүлж зарласан уу?

2023 онд гүйцэтгэгч сонгон шалгарсан 475 ТАХ, 2024 он дамжин үргэлжилж байгаа 78 ТАХ буюу нийт 196,095.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 553 ТАХ-ний ХАА зарласан байна. ХАА-г төрлөөр нь авч үзвэл ажил үйлчилгээ 86.0%, бараа 12.0%, зөвлөх үйлчилгээ 2.0% тус тус эзэлж байна.

Тайлбар: Дүүргүүдийн 2023 оны төсвийн хөрөнгийн оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-г худалдан авах ажиллагаа нь хугацааны хувьд 2005 онд батлагдсан /2023.12.31-нд хүчингүй болсон/ ТБОНӨХБАҮХАТХ-ийн үйлчлэлд хамаарч байгаа тул дээрх хуулийг шалгуур үзүүлэлт болгосон.

Мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.4⁷-т заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл буюу дүүргийн ЗДТГ-ын салбарын мэргэжилтнүүд, "ИТХ-аас томилсон 55 иргэнийг оролцуулсан байна.

Шинээр 196,095.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 553 ТАХ-ний ХАА зарласан байна. Үүнээс 95% буюу 525 ТАХ-ний ХАА-ны үнэлгээний хороо 100 хүртэл хоногийн хугацаанд урилгыг нийтэлж, ХАА-г зарласан бол 5.0%-ийг буюу 27 ТАХ-г 100-аас илүү хоногийн хугацаанд буюу төрийн худалдан авах сайтад урилгыг нийтэд мэдээлж ХАА-г зарласан байна. Хавсралт 6

Зарим ТАХ-ний төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангуулаагүйгээс зураг төсөв, ажлын даалгавар боловсруулахад тодорхой хугацаа алдсан байна. Тухайлбал:

- Борооны ус зайлуулах шугам сүлжээний зураг, төсөв (ХУД 2, 15 дугаар хороо). Төсөвт өртөг: 50.0 сая төгрөг. ДЗД-ын 2023.01.05-ны өдөр үнэлгээний хороо байгуулсан. 2023.04.07-ны өдрийн ажлын даалгавар ирүүлсэн. Тендерийн баримт бичиг боловсруулж 2023.12.07-ны өдөр зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтын дэлгэрэнгүй жагсаалтад санал ирүүлэх урилгыг нийтэлсэн. Хоног:336
- Хорооны цогцолбор барилга. ДЗД-ын 2023.01.10-ны өдөр үнэлгээний хороо байгуулагдаж, захиалагчаас 2023.04.24 зураг төсөв, ажлын даалгавар ирүүлж, 2023.11.10-ны өдөр тендерийг нээлттэй зарласан. Хоног:304
- Гэрлэх ёслолын ордны номын сангийн засвар, тохижилт. Төсөвт өртөг: 176.8 сая төгрөг. Үнэлгээний хороо 2023.03.20-ны өдөр байгуулагдсан. Батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолтыг 2023.06.07-ны өдөр ирүүлсэн. Тендерийг 2023.10.04-ны өдөр зарласан. Хоног:198

Зарим дүүргийн ИТХ нь ТАХ-г батлахдаа нийт дүнгээр баталж, ЗД-ын захирамжаар хувааж, тогтоолоор баталсан ТАХ-г багцлан тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулан ажилласан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 5⁸ дахь заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- СБД нь "Зураг төсөв боловсруулах" 1,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г 14 ТАХ болгон задалсан. Эдгээр ТАХ-ний 3 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 11 ТАХ-г шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан. Хавсралт 7.
- 1. СХД нь "Зураг төсөв хийлгэх зардал" 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г 39 ТАХ болгон задалсан. Эдгээр ТАХ-ний ХАА-г тендер

⁷ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

⁸ 8.5.Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

шалгаруулалтын онцгой журмаар шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулсан. Хавсралт 8.

Хүснэгт 12. ТАХ-г хуваасан байдал

№	Дүүрэг	ТАХ-ний нэр	(сая.төг)			
			Баталсан		хуваасан	
			Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	СБД	Зураг төсөвт боловсруулах	1	1,100.0	14	1,100.0
2	СХД	Зураг төсөвт боловсруулах	1	550.0	39	550.0

Дээрх дүүргүүдээс зураг төсөв боловсруулах ажлын хувьд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар ХАА-ны гүйцэтгэгчийн сонгон шалгаруулахад гүйцэтгэгчийн ажлын ачаалал их болдог, нэгэн зэрэг олон зургийн ажил гүйцэтгэхэд хугацаа их шаардагдаж, ТАХ-ний хэрэгжих хугацаа удаашрах, тооцоолол дутуу хийгдэх зэрэг эрсдэл бодит байдалд үүсдэг талаар тайлбар ирүүлсэн.

Дүгнэлт: ТАХ-ний төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй ТАХ-г баталснаас шалтгаалж зарим ажлын ХАА удааширсан байна.

Б.2.1.2 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган, сонгон шалгаруулалтын журмыг зөв сонгож, хууль журмын дагуу шалгаруулсан уу?

Дүүргүүдийн 3Д нарын 153 удаагийн захирамжаар ХАА-г зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороодыг байгуулсан.

ХАА зохион байгуулсан ТАХ-ний худалдан авалтын 43.7%-ийг нээлттэй тендер шалгаруулалт, 37.5%-ийг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 5.1%-ийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох, 13.7%-ийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийж тус тус зохион байгуулжээ.

Хүснэгт 13. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан журам

№	Дүүргийн нэр	Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Нээлттэй тендер шалгаруулалтын журам		Тендер шалгаруулалтын онцгой журам		Цахим дэлгүүр		Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	БГД	115	8,488.9	13	5,578.1	42.00	1,533.2	60	1,377.6		
2	БЗД	66	62,171.1	64	61,453.7	1.00	123.4			1	594.0
3	БНД	41	3,375.0	16	2,580.5	25.00	794.6				
4	БХД	11	280.9			9.00	208.2			2	72.5
5	НД	30	931.3	3	409.5	27.00	521.9				
6	СБД	68	41,805.7	39	39,868.5	20.00	961.4			9	975.7
7	СХД	57	5,875.6	14	4,857.5	41.00	937.2			2	80.9
8	ХУД	48	22,804.2	36	21,696.0	4.00	560.8			8	547.3
9	ЧД	39	14,491.9	23	12,816.8	9.00	369.9	5	1,035.6	2	269.6
НИЙТ		475	160,224.6	208	149,260.6	178	6,010.6	65	2,413.2	24	2,540.0

2023 онд ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 160,224.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 475 ХАА-аас 147,471.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 315 ХАА буюу 66.0%-ийг аудитын түүвэрт хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Хүснэгт 14. ХАА-ны илэрсэн зөрчил

№	Дүүргийн нэр	Гүйцэтгэгч сонгон шалгарсан		Үүнээс түүвэрт хамруулсан		Үүнээс илэрсэн зөрчил	
		Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ	Тоо	Гэрээний үнэ
1	БГД	115	8,488.9	74	6,359.8	1	96.6
2	БЗД	66	62,171.1	43	56,256.5	5	6,413.3
3	БНД	41	3,375.0	22	2,486.0	1	327.2
4	БХД	11	280.9	11	280.2		
5	НД	30	931.3	16	916.1	2	258.5
6	СБД	68	41,805.7	28	36,728.9		
7	СХД	57	5,875.6	52	5,203.2	2	124.5
8	ХУД	48	22,804.2	30	24,748.8	3	2,006.5
9	ЧД	39	14,491.9	39	14,491.8	8	2,441.8
Нийт		475	160,224.6	315	147,471.3	22	11,668.6

БГД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ-нд:

- Боловсролын байгууллагад шаардлагатай барилгын засвар. Гэрээний дүн: 96.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жигүүрт хөсөг ХХК. "ТАХ-г гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизм нь өөрийн эзэмшлийнх байхаар ТББ-т заасан ч гүйцэтгэгчээр шалгарсан "Жигүүрт Хөсөг" ХХК-ний ирүүлсэн материалд FAW ачааны машин нь хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгсэл байх" шаардлага хангаагүй байхад шалгаруулсан.

БЗД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- БЗД-ийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог цуглуулах цэгүүдийн шинэчлэлт, суурилуулалтын ажил. Гэрээний дүн: 887.4 сая төгрөг. Гүйцэтгэгч: Цагаанаа амка ХХК. ТББ-т тусгагдсан Ижил төстэй ажилд: *"Хогийн сав үйлдвэрлэсэн, нийлүүлсэн, гүйцэтгэсэн ажлыг тооцно"* гэж заасан ч гүйцэтгэгчийн өмнө хийж хэрэгжүүлсэн *"БЗД-ийн хүүхэд хамгааллын байр худалдан авах ажил"*-ын гэрээг дээрх ижил төстэй ажилд тооцсон нь шаардлага хангаагүй байна.
- 0.69 км авто замын засвар, шинэчлэлтийн ажил. Гэрээний дүн: 675.2 сая төгрөг. ТББ-т шаардсан тусгай зөвшөөрлийн 2.8.2.7 дахь заалтыг гүйцэтгэгчээр шалгарсан Эко эвсэг зам ХХК хангаагүй байхад сонгон шалгаруулсан байна. Мөн цахим системээс татсан тус компанийн талаарх мэдээлэлд тусгай зөвшөөрлийн дээрх заалт бүртгэгдээгүй.
- Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн /Ай Жи Эм/-ийн дугуйн зам, тохижилтын ажил. Гэрээний дүн: 3,702.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: Цонбон тоосго ХХК. ТББ-т *"2021, 2022 онд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын мэдээлэл ирүүлнэ"* гэж тусгасан ч *"2019 оны гэрээ, 2022 оны комиссын акт"* ирүүлсэн, ижил төстэй ажлын шаардлага хангаагүй байхад шалгаруулсан.
- БЗД-ийн *"Цэцэрлэгүүдийн анги танхимын тохижилтын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн ажил"*. Гэрээний дүн: 298.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Эрчим экспресс стандарт ХХК. *"Өмнөх оны ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээт ажлын дүн нь 700.0 сая төгрөг байх"*-аар заасан ч 2022 оны борлуулалтын орлого нь 639.3 сая төгрөг байсан, санхүүгийн тайлангийн борлуулалтын орлого нь шаардлага хангаагүй байна.
- Нийтийн эзэмшлийн орон сууцны гадна фасадын ажил. Гэрээний дүн: 849.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ган мөнхжин ХХК. ТББ-т *"ачааны машин 5 тн -с дээш"* гэж заасан ч Ган мөнхжин ХХК-ний санал болгосон нь портер нь 3.2 тн байна. Мөн *"үйлчилгээний машин нь өөрийн эзэмшлийнх байх"* гэж заасан ч хувь хүний эзэмшлийн машины гэрчилгээ ирүүлсэн нь шаардлага хангаагүй байна. ТББ-т шаардсан өмнө гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээ нь 2021, 2022 онуудын жил тус бүр үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх, гэрээний хуулбар, комисс хүлээж авсан актын хуулбар ирүүлэх гэж заасан ч Ган мөнхжин ХХК нь 2022 онд байгуулсан нэмэлт ажлын гэрээ ирүүлсэн, комисс хүлээж авсан актын хуулбар ирүүлээгүй нь шаардлага хангаагүй байна.

БНД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- Зам талбайн цэвэрлэгээ, задгай тэвштэй өөрөө буулгагч болон бохир усны авто машин Гэрээний дүн: 327.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Эм Би Би Импекс ХХК. ТББ-т 2021, 2022 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй /төсөвт өртөг: 380.0 сая/ гэсэн заалтыг зөрчин борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь 2021 оны борлуулалтын орлого 165.7 сая төгрөг, 2022 оны хагас жилийн борлуулалт нь 44.5 сая төгрөг буюу дундаж орлого нь 105.1 сая төгрөг байгаа нь ТББ-т заасан шаардлага хангаагүй байхад шалгаруулсан.

НД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- Цас цэвэрлэх машин худалдан авах. Гэрээний дүн: 89.1 сая төгрөг.

Хог тээврийн машин худалдан авах. Гэрээний дүн: 169.4 сая төгрөг. Эдгээр ажлуудын гүйцэтгэгчээр Талын усны гол ХХК шалгарсан байна.

ТББ-т *“үйл ажиллагааны чиглэл гадаад, дотоод худалдааны чиглэл”* гэж шаардсан ч, *“автomaшины засвар үйлчилгээ, барилгын засвар, барилгын материалын худалдаа, фермерийн аж ахуй”* гэсэн, санал болгосон машины катологи нь Монгол хэл дээр байх ёстой байтал орчуулгагүй, Англи хэл дээр байна. Нийлүүлэх машины катологи, ирүүлсэн машины гаалийн бичиг нь зөрүүтэй, өөр зураг ирүүлсэн. Мөн ТББ-ийг V бүлгийн тендер илгээх Маягт 1-т тусгасан шаардлагын дагуу ирүүлээгүй, хүчингүй болсон маягтаар ирүүлсэн. Дээрх 2 ТАХ-ний ТББ-т тусгагдсан шаардлагууд нь харилцан адилгүй байхад үнийн саналаас бусад бүх үзүүлэлт ижил баримт материал ирүүлсэн байна. /Цас цэвэрлэх машин, Хог тээврийн машин 2-ийн техникийн болон ТББ-т шаардсан үзүүлэлтүүд нь өөр өөр байна./

СХД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- Цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах. Гэрээний дүн: 48.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Эм си ар эл ХХК. ТББ-ийг V бүлгийн тендер илгээх Маягт 1-т тусгасан шаардлагын дагуу ирүүлээгүй, хүчингүй болсон маягтаар ирүүлсэн.
- Жаргалант тосгоны соёлын ордонд ариун цэврийн өрөө байгуулах. Гэрээний дүн: 76.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Люкс даймонд ХХК. ТББ-т шаардсан сантехникч, түүний мэргэжлийн үнэмлэлийн мэдээлэл ирүүлээгүй. ТББ-ийг V бүлгийн тендер илгээх Маягт 1-т тусгасан шаардлагын дагуу ирүүлээгүй, хүчингүй болсон маягтаар ирүүлсэн.

ХУД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- Ажилчны алдар талбайн тохижилт. Гэрээний дүн: 838.8 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хан билүү ХХК. ТББ-т *“мэргэжлийн ажилтны диплом нь Монгол хэл дээр байх”*-аар заасан ч орчуулаагүй, гадаад хэлээр байна. *“Ижил төстэй гэрээний дүн нь 451.8 сая төгрөгөөс дээш байх”*-аар шаардсан ч Хан билүү ХХК-ийн өмнө гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний дүн 360.0 сая буюу шаардлага хангаагүй, мөн “өмнө гүйцэтгэсэн ажлын талаар захиалагчаас тодорхойлолт ирүүлэх”-ээр заасан ч ирүүлээгүй. ТББ-т заасан “70 хувиас бага гүйцэтгэлтэй өөр ажил хийж байгаа тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно” гэж заасан ч заалтыг зөрчин тохижилтын ажлын гэрээний гүйцэтгэл нь 40 хувьтай байхад шалгаруулсан байна.
- Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /11, 19, 20 дугаар хороо/ Гэрээний дүн: 851.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Эко эвсэг зам ХХК. ТББ-т заасан “Сүүлийн 2021, 2022 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа 428.0 сая төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тохижилтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх гэж заасны дагуу гүйцэтгэгч ижил төстэй ажлын гэрээнд 420.1 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээний мэдээлэл илгээсэн.
- Сагсан бөмбөгийн 3х3 талбай байгуулах (Нисэх Яармагийн бүс) Гэрээний дүн: 316.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: Нано бриллиант констракшн ХХК. ТББ-т шаардсан 5 туслах ажилтны гэрээ болон нийгмийн даатгалын тодорхойлолт ирүүлээгүй.

ЧД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан ТАХ:

- Камержуулалт /2 дугаар хороо/ Гэрээний дүн: 89.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Мон стийл фиксер ХХК. ТББ-т шаардсан камержуулалтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан гэрээ, ажил хүлээлцсэн акт, захиалагч байгууллагын тодорхойлолт ирүүлээгүй, Инженер, техникийн ажилчид нь тухайн байгууллагын үндсэн ажилтнууд байх гэснийг зөрчин ерөнхий инженер нь үндсэн ажилтан биш хөлсөөр ажиллах гэрээтэй байна.
- Хороодын гэрэлтүүлэг. Гэрээний дүн: 289.9 сая төгрөг. Гүйцэтгэгч: Тэнгэр цэгцрээ ХХК. ТББ-т шаардсан талбайн инженерийн дипломын хуулбар ирээгүй, туслах ажилтны мэргэжлийн үнэмлэхийн хуулбарыг орчуулаагүй ирүүлсэн.
- Камержуулалт /3 дугаар хороо/ Гэрээний дүн: 89.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Мон стийл фиксер ХХК. ТББ-т шаардсан камержуулалтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан гэрээ, ажил хүлээлцсэн акт, захиалагч байгууллагын тодорхойлолт ирүүлээгүй,

Инженер, техникийн ажилчид нь тухайн байгууллагын үндсэн ажилтнууд байх гэснийг зөрчин ерөнхий инженер нь үндсэн ажилтан биш хөлсөөр ажиллах гэрээтэй байна.

- Камержуулалт /12, 21 дугаар хороо/ Гэрээний дүн: 69.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: Мон стийл фиксер ХХК. ТББ-т шаардсан камержуулалтын ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан гэрээ, ажил хүлээлцсэн акт, захиалагч байгууллагын тодорхойлолт ирүүлээгүй, Инженер, техникийн ажилчид нь тухайн байгууллагын үндсэн ажилтнууд байх гэснийг зөрчин ерөнхий инженер нь үндсэн ажилтан биш хөлсөөр ажиллах гэрээтэй, туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ нь төсөвт өртгийн 10 хувиас хэтэрсэн гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.
- Биеийн тамир спорт хороонд шаардлагатай тоног төхөөрөмж. Гэрээний дүн: 40.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Санаа мед трейд ХХК. Тус компанийн материалд үйлдвэрлэгчийн каталогийг орчуулаагүй, гадаад хэл дээр ирүүлсэн байна.
- ЧД-ийн “Цагдаагийн газрын барилгын ажлын зураг төсөв”. Гэрээний дүн: 115.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Хязгааргүй шулуун ХХК. ТББ-т *“борлуулалтын орлого нь нийт төсөвт өртгийн 50 хувиас багагүй /60 сая төгрөг/ байх”*-аар заасан ч тус компани нь 2021 онд 16.4 сая, 2022 онд 19.8 сая төгрөг буюу борлуулалтын орлогын дундаж нь 18.0 сая төгрөг байна. ТББ-т заасан шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байна.
- Хорооны барилга худалдаж авах. Гэрээний дүн: 1,390.0 сая төгрөг. Гүйцэтгэгчээр шалгарсан Галакси БДМ ХХК нь ТББ-т шаардсан 2020 оны ижил төстэй ажлын гэрээ ирүүлээгүй. 2021, 2022 онд ижил төстэй ажил гүйцэтгэхээр ирүүлсэн гэрээний үнийн дүн нь санхүүгийн тайланд тусгагдаагүй байна.
Мөн ТББ-т тусган баталсан *“2021, 2022 онуудын борлуулалтын дундаж нь батлагдсан төсвийн 50 хувиас багагүй байна”* гэж заасныг оролцогч нараас хүсэлт тодруулга гаргаагүй байхад өөрчилж *“2020, 2021, 2022 оны борлуулалтын талаарх мэдээлэл ирүүлнэ”* гэж шаардлага нөхцөлийг бууруулан ЧД-ийн ХААА-ны 2023.04.06-ны өдрийн 57 тоот албан бичгээр оролцогчдод хүргүүлсэн нь ТБОНХБАҮХАТХ-ийн 22.3⁹-т заасныг зөрчиж байна.
- Дүүргийн соёлын төвд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж. Гэрээний дүн: 358.3 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ай Ти Скайвишн Ворлд ХХК. ТББ-т шаардсан цахилгааны техникч нь тухайн компанийн үндсэн ажилтан байхаар заасан ч НД маягтаар баталгаажаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

Аудитын түүвэрт хамруулсан 315 ХАА-ны гүйцэтгэгчээс ирүүлсэн баримт, материалыг тендерийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдтэй тулган шалгахад 11,668.7 сая төгрөгийн гэрээний дүн бүхий дээрх 22 ХАА-нд шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь ТБОНХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3 “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэсэн заалтыг зөрчжээ.

Цаашид илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг үнэн зөвөөр үнэлэх, шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоож, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: Гүйцэтгэгч сонгон шалгарсан 160,224.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 475 ХАА-аас 4.6% буюу 11,668.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 22 ХАА-ны гүйцэтгэгч ТББ-т заасан шаардлага хангаагүй байна.

⁹ 22.3.Тендерт оролцогч тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын таваас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно.

Б.2.2.Захиалагч нь төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Дүүргүүдэд өмнөх оноос дамжин хэрэгжсэн болон шинээр эхэлсэн 253,418.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 618 ТАХ-ний гүйцэтгэлд дүүргүүдийн ЗДТГ-ын ТНААХ болон “НХОГ” ОНӨААТҮГ, НЗХГ, “Сэтгэшгүй нэмэх” ХХК, “Сод Си Би Ар инженеринг” ХХК, “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ, “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ зэрэг байгууллагууд захиалагчийн хяналт хэрэгжүүлжээ.

Хүснэгт 15 . Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй байгууллагууд

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	НХОГ	НЗХГ	ЗДТГ, ТНААХ	Сэтгэшгүй нэмэх ХХК	Сод Си Би Ар ХХК	“Чингэлтэй ХОББДТ” ОНӨТҮГ	Захиалагчийн алба ОНӨААТҮГ
1	БГД	118			96	2	20		
2	БЗД	106	52	38	16				
3	БНД	40			40				
4	БХД	13			13				
5	НД	34			34				
6	СБД	83	9	1	73				
7	СХД	58			45				13
8	ХУД	90	10	5	75				
9	ЧД	76			63			13	
	НИЙТ	618	71	44	455	2	20	13	13

Захиалагчийн хяналт төлөөлөн хэрэгжүүлж буй газрууд нь гүйцэтгэгчтэй захиалагчийн хяналтын гэрээ байгуулаагүй, шаардлагад нийцээгүй зэрэг зөрчилтэй байна. Үүнд:

- Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.2¹⁰ заалтын дагуу захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхээр заасан байна. ЧД-ийн ЗДТГ нь захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ-тай 2022.07.08-ны өдөр “Захиалагчийн хяналтыг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ”-г байгуулсан. Гэтэл “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ нь захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгч газартай “Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээ” байгуулаагүй нь ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоол "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.1.3¹¹-д заасныг зөрчсөн байна.
- БГД-ийн ЗДТГ нь “Сод Си Би Ар” ХХК-тай 2023.05.15-ны өдөр "Захиалагчийн хяналтыг төлөөлөн хэрэгжүүлэх" гэрээг байгуулсан. Гэтэл “Сод Си Би Ар” ХХК нь "Захиалагчийн хяналтыг төлөөлөн хэрэгжүүлэх" сонгон шалгаруулалтад заасан үндсэн шаардлагад нийцээгүй. Тухайлбал компанийн инженер техникийн ажилтнууд нь 3-аас дээш жилийн ажлын туршлагатай тухайн байгууллагын үндсэн ажилтан байх байтал 9 инженер нь үндсэн бус гэрээний үндсэн дээр ажилладаг, шинээр буюу 2023.03 сард үүсгэн байгуулагдсан компанитай гэрээ байгуулсан.

2023 онд 256,480.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 714 ТАХ хэрэгжиж байгаагаас 2023 онд 102,118.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 461 ТАХ хэрэгжиж дууссан байна. Үүнээс аудитын түүвэрт 180 ТАХ-г хамруулан шалгахад 15 ТАХ-нд зөрчил илэрлээ.

¹⁰ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹¹ 3.1.3.Барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө (график)-г баталж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах;

Б.2.2.1 Гүйцэтгэгч нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцүүлэн гэрээний хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэхэд захиалагч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн үү?

Дүүргүүдийн хэмжээнд 256,480.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 714 ТАХ хэрэгжиж байгаагаас 2023 онд 102,118.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 461 ТАХ хэрэгжиж дууссан.

Хүснэгт 16. 2023 онд хэрэгжсэн, он дамжсан, хэрэгжээгүй ТАХ

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан ажил		Он дамжин хэрэгжиж байгаа		Хэрэгжээгүй	
				тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БГД	132	9,037.1	113	7,135.0	5	1,902.2	14	-
2	БЗД	115	86,408.9	53	24,121.2	53	61,655.3	9	632.5
3	БНД	60	3,464.9	31	2,587.5	9	857.4	20	20.0
4	БХД	13	295.8	12	246.5	1	49.3	-	-
5	НД	35	1,224.6	31	967.5	3	257.0	1	-
6	СБД	92	67,967.9	63	32,888.3	20	35,079.6	9	-
7	СХД	70	6,214.3	54	5,328.6	4	885.6	12	-
8	ХУД	108	62,195.4	46	19,395.1	44	40,044.5	18	2,755.7
9	ЧД	89	19,671.9	58	9,449.0	18	10,223.0	13	-
Нийт		714	256,480.8	461	102,118.7	157	150,953.9	96	3,408.2

Харин 150,953.9 сая төгрөгийн дүнтэй 157 ТАХ нь 0-95%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байгаа, 3,408.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 96 ТАХ тухайн онд хэрэгжиж эхлээгүй байна. Хэрэгжилт нь удааширсан ТАХ-ны шалтгааныг тодруулахад дараах байдалтай байна. Тухайлбал:

- БГД-т Тохижилт бүтээн байгуулалтын ажлын зураг төсөв. Гэрээний дүн: 159.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Зууны гүүр ХХК. 2022-2023 онд дуусах тус ажлын газар чөлөөлөлт хийгдэж дуусаагүйгээс шалтгаалж хийгдээгүй.
- БЗД-т Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, спорт заал, тохижилтын ажил. Гэрээний дүн: 2,752.1 сая төгрөг. Гүйцэтгэгч: Жилкэр ХХК. 2023-2024 он дамжин хэрэгжих тус ТАХ нь зураг төсөвгүй батлагдсан, зураг төсөв боловсруулах, техникийн нөхцөл гарах ажлууд нь удаашралтай байгаагаас шалтгаалан ажил эхлээгүй.
- БЗД-ийн “0.15 км авто замын ажил (38 дугаар хороо)”. Гэрээний дүн: 290.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Сакод импорт” ХХК. 2023 онд дуусах тус ТАХ-ний байршил солигдож, тендер шалгаруулалт удааширч, гүйцэтгэгч оройтож шалгарсан, технологийн зогсолт хийсэн.
- БЗД-ийн “2.0 км авто замын ажил (35 дугаар хороо)”. Гэрээний дүн: 3,037.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: Таны зам ХХК. 2023-2024 онд дуусах тус ТАХ-ний газар чөлөөлөлтийн асуудал удааширснаас ажил эхлээгүй.
- БЗД-ийн “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн (Ай Жи Эм)”-ийн дугуйн зам, тохижилтын ажил (28 дугаар хороо). Гэрээний дүн 3,732.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Цонбон тоосго” ХХК. 2023-2024 онд дуусах Олон улсын цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөө батлагдаагүйн улмаас дугуйн зам, тохижилтын ажил удааширсан.
- БЗД-ийн 1, 5, 6, 7, 9, 13, 15, 17, 20, 25 дугаар хороодод явган зам, талбайн шинэчлэлтийн ажил. Гэрээний дүн: 3,732.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Хөрөнгийн бэл” ХХК. Тус ажил нь НЗДТГ-ын хэрэгжүүлж буй ТАХ-ний байршилтай давхардсан, мөн ажлын даалгавар, зураг төсвийн ажил нь удааширсан.
- СБД-т “7 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төв, цагдаа, хорооны ажлын албаны нэг цэгийн үйлчилгээний байр шинээр барих” ажил. Гэрээний дүн: 592.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: “ТЭТҮ” ХХК. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хүрээнд ажлыг үргэлжлүүлэхэд шүүхийн маргаантай холбоотой асуудлаас болж 2015 оноос хойш барилгын ажил зогсонги байдалтай байна. 2024 оны 03 дугаар

сарын 21-ний өдрийн Давж заалдах шатны шүүхийн шийдвэр СБД-ийн ЗДТГ-ын талд шийдвэрлэгдсэн байна.


- ЧД-т Иргэд, хүүхэд залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв, спорт заал барих /12, 13, 14, 15 дугаар хороодын дунд/. Гэрээний дүн: 1,496.7 сая төгрөг. Гүйцэтгэгч: Баян могод ХХК. Ажлын гүйцэтгэл: 38%, Тус ТАХ шүүхийн маргаантай асуудлаас шалтгаалж барилгын ажил зогссон байна.
- ЧД-т “Хоймор хайрхан амралт, сувилал ОНӨТҮГ-ын барилгын зураг төсөв” Гэрээний дүн: 61.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: Аркосис ХХК. ТАХ-г хэрэгжүүлэх газар нь ДЗД болон НЗД-ын захирамжтай газар. 2 өөр захирамжтай газар нэгтгэн 1 захирамжаар ТАХ-г хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн.

Аудитын түүвэрт хамруулсан ТАХ: 2023 онд хэрэгжиж дууссан 150,953.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 461 ТАХ-ний төрөл бүрээс түүвэрлэн 67,158.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 180 ТАХ-г хамруулан газар дээр нь шалгаж тулган баталгаажуулалт хийхэд зураг төсөвт тусгагдсан ажлууд дутуу хийгдсэн, чанаргүй гүйцэтгэсэн зөрчлүүд илэрлээ.Үүнд:


БГД-ийн ТНААХ, “Сод Си Би Ар Инженеринг” ХХК -аас хяналт тавьсан ТАХ-г шалгахад: Орчны тохижилт (6, 7, 9 дүгээр хороо). Гэрээний дүн: 285.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Интел хайтек ХХК. Ажлын тоо хэмжээнд заасан 10 ширхэг шилмүүст модыг дутуу суулгасан, ажлын гүйцэтгэлээр хүлээн авсан. /дулааны улиралд суулгахаар/

БЗД-ийн ТНААХ, НЗХГ, НХОГ-ын хяналт тавьсан 27,359.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 44 ТАХ-г шалгахад:

- Тохижилтын ажил (25 дугаар хороо). Гэрээний дүн: 245.2 сая төгрөг Гүйцэтгэгч: "Люксдаймонд" ХХК Ногоон байгууламж, зүлэгжүүлэх ажил хийгдээгүй, явган замын эхлэл төгсгөлийн тэмдэглэгээг стандартын дагуу хийгээгүй байна.



- Явган зам, авто зогсоолын засвар, шинэчлэлтийн ажил (12 дугаар хороо) Гэрээний дүн: 228.8 сая төгрөг Гүйцэтгэгч: “Бат люкс” ХХК. Зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ хийгдээгүй, явган замын зарим хэсэг суулт өгсөн, траншейны нүх тойрсон бетон эвдэрсэн.



- Нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр засварын ажил (7 дугаар хороо). Гэрээний дүн: 160.9 сая төгрөг Гүйцэтгэгч: "Онч тэнхлэг" ХХК. Ажлыг чанаргүй хийснээс

шалтгаалан 36Г байрны дээд давхрын шатны хонгилын таазнаас дусаал дуссан байна.



- БЗД-ийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайн хог цуглуулах цэгүүдийн шинэчлэлт, суурилуулалтын ажил. Гэрээний дүн: 887.5 сая төгрөг Гүйцэтгэгч: Цагаанаа амка ХХК. БЗД-т нийлүүлсэн хог цуглуулах 115 цэгийн хогийн сав дээр өгөгдсөн зургийн дагуу хаягийг бичээгүй, иргэд хог хаяхдаа гарч зогсдог гишгүүрийг хийгээгүй, хогийн савыг зарим байршилд суурилуулахдаа доод сууринд нь хатуу хучилт хийгээгүй байна.



- БЗД-ийн авто замын засвар, шинэчлэлтийн ажлын 18 байршилд хэрэгжиж дууссан 13,067.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ-ний зарим байршилд зам арчлалтаас шалтгаалан замын хашлага эвдэрсэн. НЗХГ-ын хяналт хэрэгжүүлсэн инженер болон гүйцэтгэгч компанийн ажилтнууд замын хашлаганы эвдрэлийн шалтгааныг цас хайлуулах бодис, давсыг замын зорчих хэсгээс цэвэрлэж, замын хашлага хэсэгт овоолсноос үүдэн давс, бодист идэгдсэн гэсэн тайлбарыг өгсөн.




СХД-ийн “Захиалагчийн алба” ОНӨААТҮГ-ын хяналт тавьсан 3,830.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 10 ТАХ-г шалгахад:

- 118 дугаар цэцэрлэгийн тохижилтын ажил. Гэрээний дүн: 436.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: СХД-ийн “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ. Тохижилтын ажлын тоо хэмжээнд заасан ажлаас хогийн сав 3 ширхэг дутуу, бялдаржуулах төхөөрөмж (2.5 м өндөртэй) 3 ширхэг дутуу суурилуулсан.

ХУД-ийн ТНААХ-ийн хяналт тавьсан 15,444.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 23 ТАХ-г шалгахад:

- Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн шинэчлэл засварын ажил. Гэрээний дүн: 372.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ти Эйч Эн ХХК. Ажлын тоо хэмжээнд заасан ханын камер 5 ширхэг дутуу суурилуулсан.



- 4 дүгээр клиник сувиллын барилгын гадна тохижилт. Гэрээний дүн: 229.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Мета менежмент ХХК. Сагсан бөмбөгийн талбайн будаг хуурч, гадаргуу гэмтсэн.



- Усан спорт сургалтын төвийн дээвэр, фасад засвар. Гэрээний дүн: 478.2 сая төгрөг. Гүйцэтгэгч: Гурван хажинга трейд ХХК. Дээврийн тодорхой байршилд хар цаас хавагнаж хөөнгө үүссэн.



- Усан спорт сургалтын төвийн барилгын агаар сэлгэлт, салхивчийн засвар, шинэчлэлтийн ажил. Гэрээний дүн: 161.6 сая төгрөг. Гүйцэтгэгч: “Түмэн наяд хайрхан” ХХК. Гүйцэтгэгч байгууллага ашиглагч байгууллагын ажилтан, албан хаагчдыг сургалт мэдээллээр дутуу хангаснаас, ашиглалтын горим алдагдуулсан. Энэ асуудлаас үүдэн агааржуулалтын систем доголдож, саун болон фитнесийн өрөөнд хөлрөлт үүссэн.

ЧД-ийн “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ-ын хяналт тавьсан 5,399.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 18 ТАХ-г шалгахад:

- Хүүхдийн тоглоомын талбайн засварын ажлууд - 1. Гэрээний дүн: 135.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Лумос Максима ХХК. Ажлын тоо хэмжээнд заасан хогийн сав 1 ширхэг дутуу, байрлуулсан 1 ширхэг хогийн сав, чийрэгжүүлэх төхөөрөмж эвдэрсэн, сагсан бөмбөгийн талбайн будаг нь хуурсан. Тоглоомын талбайн зөөлөвч резин ховхорч эвдэрсэн.

- Хүүхдийн тоглоомын талбайн засварын ажлууд - 2. Гэрээний дүн: 74.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Ай Эм Ди ХХК. Ажлын тоо хэмжээнд заасан ногоон байгууламжийн хүрээнд 8 ширхэг бургас мод суулгасан боловч алга болсон.
- Хүүхдийн тоглоомын талбайн засварын ажлууд - 3. Гэрээний дүн: 79.5 сая төгрөг. Гүйцэтгэгч: Гурван гялаан ХХК. Тоглоомын талбайд 12 ширхэг зөөлөвч резинэн хавтан байхгүй.
- 6 дугаар хороонд тохижилт болон авто замын ажил. Гэрээний дүн: 49.0 сая төгрөг. Гүйцэтгэгч: Топ буянт зам ХХК. Ажлын тоо хэмжээнд заасан тоглоомын талбайн резинэн хавтан ховхорсон, хашааны шонгууд болон пүршин суурьтай тоглоом унасан, модон суурьтай сандлын тавцан хугарсан.

Иймд гүйцэтгэгчийн болон захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй албан хаагчдын үүрэг хариуцлагыг сайжруулж, эвдэрсэн болон дутуу, чанаргүй хийсэн ажлуудыг дахин хийлгэж эргэн мэдэгдэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар хугацаатай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: Аудитын түүвэрт 67,158.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 180 ТАХ-г хамруулан шалгахад 15 ТАХ буюу 8.3%-д нь зураг төсөвт тусгагдсан ажлууд дутуу хийгдсэн, ажлыг чанаргүй гүйцэтгэсэн зөрчлүүд илэрч байна.

Б.2.2.2 Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн хууль, журамд заасны дагуу олгосон уу?

Дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 624 ТАХ-нд 2023 онд 250,459.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 477 ТАХ 132,241.1 сая төгрөг буюу 52.8%-ийн санхүүжилт олгожээ.

Үүнээс өмнөх оноос дамжин санхүүжих 186 ТАХ-нд 64,848.4 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 39,337.7 сая төгрөг буюу 60.6%-ийн санхүүжилт олгожээ.

Хүснэгт 17. ТАХ-ний санхүүжилтийн судалгаа

(сая.төг)

№	Дүүргийн дүн	Өмнөх оноос хэрэгжсэн				2023 онд шинээр хэрэгжсэн				Нийт			
		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	4	229.4	3	197.6	129	14,953.0	112	7,668.2	133	15,182.4	115	7,865.8
2	БЗД	39	17,018.1	33	10,657.5	70	55,464.5	52	31,842.2	109	72,482.6	85	42,499.7
3	БНД	18	1,696.2	15	1,371.2	42	3,333.4	20	1,177.2	60	5,029.5	35	2,548.4
4	БХД	2	15.0	2	15.0	11	288.5	11	271.1	13	303.5	13	286.1
5	НД	2	113.4	1	33.7	33	1,150.8	31	1,093.1	35	1,264.3	32	1,126.8
6	СБД	26	13,727.2	19	7910.2	37	46,800.0	31	26,210.5	63	60,527.2	50	34,120.7
7	СХД	11	4,127.7	7	1,993.3	23	12,029.4	13	6,613.4	34	16,157.1	20	8,606.6
8	ХУД	37	15,479.4	30	10,843.9	60	34,048.5	36	12,242.6	97	49,527.9	66	23,086.5
9	ЧД	47	12,442.0	44	6,315.3	33	17,543.3	17	5,785.1	80	29,985.3	61	12,100.5
	Нийт	186	64,848.4	154	39,337.7	438	185,611.4	323	92,903.4	624	250,459.8	477	132,241.1

Нийт олгосон 132,241.1 сая төгрөгийн санхүүжилтээс 1,449.3 сая төгрөгийг дүүргүүд техник хяналтын зардал болон зураг төсөв, магадалшгүй ажил, зохиогчийн хяналтын зардалд зарцуулсан.

Хэрэгжиж дууссан ТАХ-ний барьцаанд 5,401.4 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн 64 гүйцэтгэгчээс гэрээний хугацаа хэтрүүлсэн алдангид 97.7 сая төгрөг суутган тооцож дүүргийн төрийн сангийн дансанд байршуулжээ.

Хүснэгт 18. 2023 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги

(сая.төг)

№	Дүүргийн нэр	Батлагдсан төсөвт өртөг		Олгогдсон санхүүжилт		Барьцаанд		Алданги	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	133	15,533.0	115	7,865.8	55	284.4	12	30.6
2	БЗД	109	92,945.1	85	42,499.7	54	1,231.4	3	2.2
3	БНД	60	5,029.5	35	2,548.4	25	107.1	4	5.8
4	БХД	13	303.5	13	286.1	11	17.8	3	0.4
5	НД	35	1,264.8	32	1,126.8	32	56.4	-	-
6	СБД	63	80,043.8	50	34,120.7	44	2,293.7	3	6.4
7	СХД	34	20,694.5	20	8,606.6	13	238.6	23	12.7
8	ХУД	97	71,703.5	66	23,086.5	25	892.0	13	32.5
9	ЧД	80	37,151.7	61	12,100.5	27	280.0	3	7.1
	Нийт	624	324,669.5	477	132,241.1	286	5,401.4	64	97.7

Санхүүжилт олгосон дансны хуулга, гэрээний хэрэгжилттэй холбоотой баримтуудыг /гэрээ дүгнэсэн протокол, ажлын гүйцэтгэл, ажил хүлээлцсэн актууд/ шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- БГД-ийн ЗДТГ нь 688.5 сая төгрөгийн үнийн дүнтэй техник, тоног төхөөрөмж худалдан авахаар “Цахим дэлгүүрээс худалдан авалт хийх ерөнхий гэрээ”-г “Технозон” ХХК-тай байгуулсан байна.

Тус гэрээний дагуу техник, тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авсны дараа төлбөрийг шилжүүлэх байтал 260 зөөврийн компьютерыг хүлээн аваагүй байхад 528.5 сая төгрөгийн төлбөрийг урьдчилан ажлын гүйцэтгэлд үндэслээгүй олгосон. Дээрх гэрээнд хугацаа хэтэрсэн тохиолдолд хариуцлага тооцох талаар тусгаагүйгээс нийлүүлэгч тал гэрээт хугацаанаас 48 хоног хөцөрч 2024.02.13-ны өдөр барааг нийлүүлсэн байна.

- БНД, БХД, НД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 3 ажлын үлдэгдэл санхүүжилт 52.9 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 7.7¹² заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 19. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан ТАХ-ний жагсаалт

(сая.төг)

Д/Д	Дүүргийн нэр	ТАХ-ний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн
1	БНД	Номын сангийн засварын ажлын зураг төсөл төсөв боловсруулах	"Скэч" ХХК	14.7	13.2	1.5
2	БХД	Дүүргийн өндөрлөгийн гадна орчны ногоон байгууламж, тохижилтын ажлын зураг төсөв боловсруулах	Ти эл жи прожект ХХК	23.3	21.2	2.1
3	НД	Ариун цэврийн байгууламж байгуулах	Баялаг өөдөс ХХК	159.2	109.9	49.3
		НИЙТ ДҮН		197.2	144.3	52.9

- СБД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс. “Ангад арвижих” ХХК-ийн гүйцэтгэсэн “Зам засварын ажлын зураг төсөв боловсруулах” гэрээний тусгай нөхцөлийн 6.4-д заасны дагуу ажлын барьцаа болох 3.1 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд бус төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.
- ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс. Дархан нэгдэл ХХК-ийн гүйцэтгэсэн Төвийн хороодод фасад засвар хийх гэрээний тусгай нөхцөлийн 6.8-д заасан ажлын барьцаа 16.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд бус төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн.

Иймд ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох, барьцаа хөрөнгийн дансанд ТАХ-ний барьцааг бүрэн төвлөрүүлэх, төсөвт тусгасан санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгох, гэрээнд алданги тооцох заалт оруулаагүй зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: Дүүргүүд нь 2023 онд тухайн онд болон өмнөх онуудаас хэрэгжсэн нийт 477 ТАХ-нд батлагдсан санхүүжилтийн 52.8%-ийг олгосон байна.

Санхүүжилтийг төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслээгүй олгосон, зарим дүүргүүд ажлын барьцааг авч үлдээгүй, өөр дансанд төвлөрүүлсэн, төсөвт татуулсан зэрэг зөрчлүүд гаргажээ.

¹² Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д заасан “төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ

БҮЛЭГ В.3. Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүнтэй байна уу?

В.3.1. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авч, өмчийн бүртгэлд авсан уу?

2023 онд 97,981.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 461 ТАХ бүрэн хэрэгжиж дууссанаас 34.0% буюу 157 ТАХ, (Үүнд: *барилга байгууламж, авто зам, засвар тохижилт, дэд бүтцийн ажил*), 66.0% буюу 304 ТАХ-г (Үүнд: *тавилга эд хогшил, тоног төхөөрөмж*) ашиглалтад авах комисс хүлээн авчээ.

Хэрэгжиж дууссан дээрх ТАХ-ээс 60,193.9 сая төгрөгийн дүнтэй 307 ТАХ-г ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгасан, 13,634.9 сая төгрөгийн дүнтэй 132 ТАХ-г шууд зардалд тусгасан байна. Харин 24,656.8 сая төгрөгийн дүнтэй 22 ТАХ-ний баримт бичгийн бүрдүүлбэр хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах зэрэг ажил үргэлжилж байна.

В.3.1.1 Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс хууль, журмыг мөрдөж ажилласан уу?

ЗГ-ын 2021 оны 212 дугаар тогтоолоор Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг баталжээ. Тус дүрэмд зааснаар “*гадна талбайн тохижилт, засварлах ажлыг ашиглалтад оруулах комисс*”-ыг дүрмийн 1-р хавсралтын 2¹³-д заасан бүрэлдэхүүнтэй байхаар тусгажээ. Аудитын түүвэрт хамруулсан ТАХ-ний хувьд комиссын бүрэлдэхүүн нь дээрх дүрмийн дагуу ажилласан байна.

Барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт, зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар, түүний биелэлт, ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа, мөн бараа материал, тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсгээс хүлээн авсан тоног төхөөрөмжийн баталгаат засвар, суурилуулалт, ажиллах горимын талаарх сургалт зохион байгуулахад дүрэм журмыг мөрдсөн эсэхийг 67,158.65 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 180 ТАХ-ний баримт материалын хүрээнд үзэхэд дараах байдалтай байна. Тухайлбал:

- Барилга байгууламж, гадна талбайн тохижилт, засварлах комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг харахад жижиг засвар, тоноглолын ажлуудыг гүйцээх, ашиглагч байгууллагын тоот, бичиг баримтын бүрдэл хангуулах зэрэгт чиглэгдсэн байна.
- Комиссын үүрэг даалгаврын биелэлтийг фото зургаар баталгаажуулан ашиглагч, хүлээн авах байгууллагын албан бичиг хавсарган, түүний биелэлтийг хангуулан ажилласан байна.
- Мэдээлэл холбоо, камер, эмнэлгийн тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсэгт нийслэлийн дүүргийн мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцуулсан бол бусад тавилга, тоног төхөөрөмж, бараа материалыг ТАХ-ны тоо хэмжээ, ажиллагааны бүрэн бүтэн байдлыг шалган хүлээн авсан байна.

Харин БГД-ийн ЗДТГ нь 528.5 сая төгрөгийн үнийн дүнтэй 37 цэцэрлэгийн 260 ширхэг i5 зөөврийн компьютер, дагалдах хэрэгслийн хамт хүлээн аваагүй байхад 2023.12.27-ны өдөр “Технозон” ХХК-аас хүлээн авснаар акт үйлдсэн байна. Гэтэл зөөврийн компьютер, дагалдах хэрэгслийг дээрх хугацаанаас 48 хоног буюу 2024.02.13-ны өдөр нийлүүлсэн байна.

¹³Комиссын дарга: Захиалагч байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Зураг төслийн байгууллагын төлөөлөл

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл

Архивын байгууллагын төлөөлөл

Дүгнэлт: Хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс хууль, журмыг мөрдөж ажилласан байна.

БГД-ийн ЗДТГ нь тоног төхөөрөмжийг бодитоор нийлүүлээгүй байхад хүлээн авснаар акт үйлдсэн зөрчил гаргасан байна.

В.3.1.2 Ашиглалтад орсон барилга байгууламж, хүлээн авсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг бүртгэлд тусгаж, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байна уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 461 ТАХ бүрэн хэрэгжиж дууссанаас барилга байгууламж, авто зам, дэд бүтцийн чиглэлийн 49 ТАХ, техник, тоног төхөөрөмжийн 215 ТАХ, их засвар, тохижилтын ажлын 108 ТАХ, зураг төсвийн 89 ТАХ байна.

Хөрөнгийн бүртгэл: Хэрэгжиж дууссан дээрх ТАХ-ээс 60,193.9 сая төгрөгийн дүнтэй 307 ТАХ-г ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгасан, 13,634.9 сая төгрөгийн дүнтэй 132 ТАХ-г шууд зардалд тусгасан байна. Харин 24,656.8 сая төгрөгийн дүнтэй 22 ТАХ-ний баримт бичгийн бүрдүүлбэр хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах зэрэг ажил үргэлжилж байна.

Хүснэгт 20. Хөрөнгийг бүртгэлд тусгасан байдал

№	Дүүргийн нэр	Хөрөнгөнд бүртгэх ТАХ		Бүртгэсэн ТАХ		Шууд зардалд тусгасан		Бүртгээгүй ТАХ	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	113	7,134.9	105	5,970.7	8	1,092.2		
2	БЗД	53	22,102.7	33	17380.3	20	5580.6		
3	БНД	32	2,439.7	21	1,857.7	2	66.0	9	234.0
4	БХД	12	246.5	10	231.5	2	15.0		
5	НД	31	967.5	17	659.5	14	308.0		
6	СБД	63	32,888.3	40	10,759.1	21	2,037.6	3	20,091.6
7	СХД	54	5,328.7	6	1,843.4	40	556.6	9	2,928.7
8	ХУД	46	19,395.1	26	16,881.9	18	2,513.2		
9	ЧД	57	7,478.1	49	4,609.8	7	1,465.7	1	1,402.5
	Нийт	461	97,981.5	307	60,193.9	132	13,634.9	22	24,656.8

Шууд зардалд тусгасан ТАХ-үүд нь хөрөнгө оруулалтын бус шинж чанартай байгаагаас өмч бүртгэлд тусгах боломжгүйд хүрсэн байна. Үүнд:

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16.6-д “Орон сууцны байшингийн ашиглалтын хугацаанд дундын өмчлөлийн эд хөрөнгөд хамаарах дээвэр, цахилгаан шат зэрэгт их засвар хийх үед их хэмжээний хөрөнгө шаардагдах бол барилгын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн улсын болон орон нутгийн төсвөөс нэг удаа санхүүжүүлж болно” гэсэн заалтыг үндэслэн 4,507.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 17 ТАХ-г зардалд бүртгэсэн байна. Хавсралт 7. Мөн Газрын тухай хуулийн 58.7 “Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн СБД-ийн зуслан, гэр хороолол, барилгажсан хэсгийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийж, 219.9 сая төгрөгийн ТАХ-г тус тус зардалд бүртгэжээ.

Хөрөнгийн ашиглалт: Шинээр хүлээн авсан барилга байгууламж, нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалттай газар дээр нь танилцахад хөрөнгийн үр ашиг нь иргэдэд хүрсэн байна. Тухайлбал:

- БЗД-т авто замын засвар, шинэчлэлтийн ажлын хүрээнд нийт 18 байршилд 13,067.1 сая төгрөгийн өртгөөр 6.4 км замыг шинээр барьсан, мөн засвар шинэчлэлт хийн ашиглалтад хүлээн авч зорчих хөдөлгөөнийг нээсэн байна.
- ХУД-ийн 21-р хороонд 3,238.6 сая төгрөгийн өртгөөр “Хороо, өрхийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга” Хороо нь 11 өрөө бүхий 511м² талбайд, өрхийн эрүүл мэндийн төв 11 өрөө бүхий 325 м² талбайд үйл ажиллагаа явуулж байна. Тус хороо нь төрийн болон эрүүл мэндийн тусламжийн анхан шатны үйлчилгээг иргэдэд үзүүлж байна.
- ЧД-ийн 20-р хороонд 1,390.0 сая төгрөгийн өртгөөр Хорооны барилга худалдан авсан байна. Тус хороо нь дүүргийн 1390 өрх, 5400 иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж байна.

Зарим хөрөнгийн ашиглалт нь хангалтгүй байна. Үүнд:

- ЧД-ийн 7-р хорооны нутаг дэвсгэрт дүүргийн Газар зохион байгуулалтын албаны үйл ажиллагааны хүрээнд зөвшөөрөлгүй барьсан хашаа, байгууламжийг түр байршуулах зорилгоор журмын хашааг 58.9 сая төгрөгийн өртгөөр барьж байгуулсан ч харуул хамгаалалтын орон тооны зардал шийдвэрлэгдээгүй шалтгаанаар ашиглалтгүй байна.
- БГД-ийн ИТХ-ын байрны 1-р давхарт 193.0 сая төгрөгийн өртгөөр байгуулсан салбар нь хэддүгээр цэцэрлэгт хамаарах, ажилтны болон урсгал зардлын тооцоолол хийгээгүй зэрэг шалтгаанаар ашиглалтгүй байсан. 2024 оны 05 сарын 01-ний өдрөөс Нийслэлийн 164 дүгээр цэцэрлэгийн салбар болон үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
- ХУД-т хэрэгжиж дууссан “Тайлан гарын авлага, брошюр хэвлэх төхөөрөмж худалдан авах”. Гэрээний дүн: 349.9 сая төгрөг. Хэвлэх, хувилах, сканердах, бүрэх машин тоног төхөөрөмж нь суурилуулах байргүй шалтгаанаар ашиглалтгүй байна.
- БЗД-т хэрэгжиж дууссан “Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийг хөдөлмөрт сургах, хөдөө аж ахуй, монгол ахуйн чиглэлээр боловсрол, төлөвшлийг олгох зорилгоор хөдөлмөр зуслан худалдан авах ажил”. Гэрээний дүн: 1,200.0 сая төгрөг. Жилийн 4 улирал ажиллах хүчин чадалтай дээрх зусланг 2023 оны 7 сард комиссын актаар хүлээн авсан ч холбогдох зардлыг тооцоолол хийгээгүйгээс ашиглалтгүй байна. Мөн “*хичээлийн жилийн улиралтай зохицуулан зуны улиралд ажиллахаар хүлээгдэж байгаа*” гэсэн тайлбарыг БЗД-ийн ЗДТГ-аас ирүүлсэн.

Дүгнэлт: Ашиглалтад хүлээн авсан тохижилт, дэд бүтэц, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг 66.5%-ийг данс бүртгэлд бүрэн тусган зориулалтын дагуу ашиглаж байна.

Хүлээн авсан хөрөнгийн 0.8%-ийн холбогдох зардлыг тооцоолоогүйгээс ашиглалтгүй байна.

В.3.2 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

Дүүргүүдэд 2023 онд шинэ болон он дамжин хэрэгжиж буй хөтөлбөр, ТАХ-нд дүүргийн ДАА төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг хийхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгажээ.

Хүснэгт 21. ДАА-аас хийхээр төлөвлөсөн хяналт, шалгалт

№	Дүүргийн нэр	Төлөвлөгөөнд тусгасан тоо	Гүйцэтгэл	Өгсөн зөвлөмж
1	БГД-ийн ДАА	1	1	3
2	БЗД-ийн ДАА	1	-	-
3	БНД-ийн ДАА	1	1	3
4	БХД-ийн ДАА	-	-	-
5	НД-ийн ДАА	-	-	-
6	СБД-ийн ДАА	-	-	-
7	СХД-ийн ДАА	1	1	6
8	ХУД-ийн ДАА	-	-	-
9	ЧД-ийн ДАА	1	1	5
	НИЙТ	5	4	17

БЗД, БХД, НД, СБД, ХУД-ийн ДАА-наас дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-нд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Харин БГД, БНД, СХД, ЧД-ийн ДАА-наас 2023 онд 4 удаагийн хяналт шалгалтыг 3 чиглэлээр хийж 17 зөвлөмж өгч ажилласан байна. Зөвлөмжийн биелэлттэй танилцахад зөвлөмжийн биелэлт, үр дүн хангалтгүй байсан.

НТАГ-аас өмнөх оны дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэл, захиалагчийн хяналттай холбоотой 4 зөвлөмж өгч ажилласан ч зөрчил арилахгүй давтагдаж байна

Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гэрээний хэрэгжилт, санхүүжилттэй холбоотой зөрчлүүд арилаагүй, дахин давтагдаж байгаа нь хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

В.3.2.1 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл нь холбогдох хууль журамтай нийцэж буй эсэхэд 2023 онд Дүүргүүдийн ДАА-аас дараах хяналт шалгалт хийсэн байна. Үүнд:

- БГД-ийн ДАА нь 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын худалдан авах, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналтыг хийж хэрэгжүүлсэн. Дотоод аудит, хяналт шалгалтаар хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 3 асуудалд зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд өгч ажилласан байна.
- БНД-ийн ДАА нь 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын худалдан авах, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналтыг хийж хэрэгжүүлсэн. Дотоод аудит, хяналт шалгалтаар хөрөнгө оруулалтын худалдан авалт, гүйцэтгэлтэй холбоотой асуудалд 3 зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд өгч ажилласан байна.
- СХД-ийн ДАА нь 2023 оны эхний 11 сарын байдлаар дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын худалдан авах, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналтыг хийж хэрэгжүүлсэн. Дотоод аудит, хяналт шалгалтаар хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудалд 6 зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд өгч ажилласан байна.

- ЧД-ийн ДАА нь 2023 онд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын төлөвлөлт, худалдан авах, гүйцэтгэл, захиалагчийн хяналт, санхүүжилтэд хийж хэрэгжүүлсэн. Дотоод аудит, хяналт шалгалтаар хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, захиалагчийн хяналттай холбоотой асуудалд 5 зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд өгч ажилласан байна.
- БЗД-ийн ДАА нь 2023 оны жилийн төлөвлөгөөндөө дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын ажилд дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан боловч, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- БХД, НД, СБД, ХУД-ийн ДАА нь жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмжийн биелэлттэй танилцахад дараах байдалтай байна.

- БГД-ийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсээс БГД-ийн ДАА-нд ирүүлсэн зөвлөмжийн биелэлтэд гүйцэтгэлтэй холбоотой баримт материалыг бүрэн бүрдүүлсэн, санхүүжилтийг олгохдоо алданги тооцож, данс бүртгэлд тусгаж ажилласан талаар хэрэгжилтийг ирүүлсэн.
- БНД-ийн ХААА-ны 2023.07.03-ны 95 тоотой БНД-ийн ДАА-нд ирүүлсэн зөвлөмжийн биелэлтэд худалдан авах ажиллагааны талаар төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган биелэлтийг ирүүлсэн байна.
- СХД-ийн ЗДТГ-ын дотоод албан бичгээр СХД-ийн ДАА-нд ирүүлсэн зөвлөмжийн биелэлтэд, хөрөнгө бүртгэл, гэрээний хэрэгжилт, ашиглалт хамгаалалтын талаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар ирүүлжээ.
- ЧД-ийн ЗДТГ-ын 2023.12.15-ны 4/3128 тоотой ЧД-ийн ДАА-нд ирүүлсэн зөвлөмжийн биелэлтэд тендерийн жишиг баримт бичиг, хөрөнгө бүртгэл, гэрээний хэрэгжилтийн талаар хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар ирүүлжээ.

Дүүргүүд нь зөвлөмжийн биелэлтийг хангуулан ажиллах талаар тодорхой арга хэмжээ хэрэгжүүлсэн ч ТАХ-ний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэл, санхүүжилттэй холбоотой зөрчил гарч зөвлөмжийн үр дүн хангалтгүй байна.

Цаашид дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод хяналтыг жил тутам хэрэгжүүлж үр дүн, үр нөлөөг бодитоор тооцож ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын үр дүн хангалтгүй байна.

В.3.2.2 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан уу?

НТАГ-аас хийсэн 2022 оны хөрөнгө оруулалтын аудитаар дүүргүүдэд төлөвлөлт, санхүүжилт, ХАА, захиалагчийн хяналттай холбоотой 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

Зөвлөмж: Биелэлтийг дүүргүүдээс ирүүлсэн ч Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г төлөвлөсөн, ХАА зохион байгуулахдаа шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан, захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлсэн, гэрээний биелэлтийг бүрэн хангуулаагүй зэрэг зөрчлүүд дахин давтагдсан.

Мөн энэ онд хийгдсэн аудитаар ТАХ-ний төлөвлөлттэй холбоотой 113,533.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 138 ТАХ, худалдан авалттай холбоотой 11,668.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 22 ТАХ, гүйцэтгэлтэй холбоотой 16,890.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 15 ТАХ, санхүүжилттэй холбоотой 6 ТАХ-нд 600.9 сая төгрөг төгрөгийн зөрчил тус тус илэрч байна.

Зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дахин давтагдан гарч байгаа тул биелэлтийг хангуулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дүгнэлт: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчил дахин давтагдаж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө зураг төсөв, газар, техникийн нөхцөлтэй байх, хөрөнгө ашиглалттай холбоотой зардлын тооцоолол хийсэн байх зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй баталжээ.
2. Худалдан авах ажиллагаа зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг баримтлаагүй байна.
3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг дутуу хэрэгжүүлснээс хөрөнгө оруулалтын ажлуудад чанарын болон ашиглалтын шаардлага хангаагүй байна.
4. 2023 онд 477 ТАХ-нд батлагдсан санхүүжилтийг 132,242.1 сая төгрөгийг олгожээ. Барьцаа дансанд төвлөрүүлээгүй, ажлын гүйцэтгэлд үндэслээгүй санхүүжилт олгосон, санхүүгийн үйл ажиллагаанд тавих шат шатны хяналт хангалтгүй байна.
5. Ашиглалтад хүлээн авсан тохижилт, дэд бүтэц, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг данс бүртгэлд тусган зориулалтын дагуу ашиглаж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Дүүргүүдийн ИТХ болон ЗД нарт:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, батлахдаа хуульд заасан төсөвлөлтийн болон бусад шаардлагыг бүрэн хангуулах, шат шатны хяналтыг сайжруулах, хариуцлагатай, сахилга баттай байх зарчмыг мөрдөн ажиллах;
2. Төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэлийн үе шатанд гардаг зөрчил арилахгүй жил бүр давтан гарч буй байдалд анхаарал хандуулах, түүнийг таслан зогсоох, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх;

Дүүргүүдийн ЗДТГ болон Худалдан авах ажиллагааны албаны дарга нарт:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангаж ажиллах;
2. Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль тогтоомжийн хүрээнд үнэлэн тендерийн баримт бичгийг баримталж ажиллах, үнэлгээний хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хууль тогтоомжийг мөрдлөг болгох;
3. Төсөл арга хэмжээг чанарын хувьд ашиглалтын шаардлага хангахуйц түвшинд гүйцэтгүүлэх, ажлын тоо хэмжээ дутуу болон чанаргүй хийсэн ажлуудыг гүйцэтгэгчдээр дахин хийлгүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх;
4. Захиалагчийн хяналт хэрэгжүүлдэг эрх бүхий нэгж, албан хаагчдын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, хяналтыг дутуу болон чанаргүй гүйцэтгүүлсэн албан хаагчдад хариуцлагыг тухай бүр хүлээлгэж хэвших;
5. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгох, барьцаа хөрөнгийн дансанд ТАХ-ний барьцааг бүрэн төвлөрүүлэх, төсөвт тусгасан санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгох;
6. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд эргэн мэдэгдэх, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар бодитой ажил хэрэгжүүлэх;

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.Нацагдоржийн талбай, Наран хороолол,
1 дүгээр хороо, Багануур дүүрэг,
Улаанбаатар хот, 12090
Утас/Факс: (976) 7021 0017, 7021 0330
Цахим шуудан: info@bnd.ub.gov.mn
Цахим хаяг: www.bnd.ub.gov.mn

2024.05.08	№	01/486
танай	2024.05.03	-ны № 776 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Цаашид илэрсэн зөрчлийг дахин гаргахгүй байхад анхааран ажиллах болно.



Багануур дүүргийн засаг даргын тамгын газар
Захиргаа
Багануур дүүргийн засаг дарга
Сумъяа Даваасүрэн
2024.05.08 17:12



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Энхтайваны өргөн чөлөө-57, 13 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас/Факс: (976-51) 26 63 59
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2024.05.08	№	02/1228
танай	2024.05.03	-ны № 776 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн "Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн (НТАГ-2024/18-11-ШТА-ГА)"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.

Цаашид тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар ТБАГУТҮГ
Удирдлага
Тамгын газрын дарга
Ичинноров Баттөгс
2024.05.08 11:20



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Өндөр толгой, 1 дүгээр хороо,
Багахангай дүүрэг, Улаанбаатар хот, 12330
Утас: (976) 7049 1011
Цахим хуудас: www.bagakhangai.ub.gov.mn

2024.05.07	№	01/347
танай	2024.05.03	-ны № 776 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2024/18ШТА-ГА/ тайланд саналгүй болно.



Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
Засаг дарга
Алтанхуяг Сүхболд
2024.05.08 08:46



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.Даваажавын гудамж, 2 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот 12790
Утас: (976) 7023 2252, 7023 2204
Цахим шуудан: nadubgov@webmail.com
Цахим хуудас: www.nad.ub.gov.mn

2024.05.08	№	02/920
танай	2024.05.03	-ны № 776 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.



Налайх Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар
Удирдлага
Засаг Дарга
Чойжинсамбуу Раднаабазар
2024.05.08 15:58



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Иргэдэд үйлчлэх төв байр, Чингисийн өргөн чөлөө,
20 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17042, Утас: (976) 7777 1965
Цахим шуудан: info@khanuul.mn
Цахим хуудас: www.khanuul.mn

2024.05.07 № 03/883
танай _____ -ны № _____ -т
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн тайлантай танилцсан.

Тайлангийн үр дүнтэй санал нийлж хүлээн зөвшөөрч байна. Цаашид алдаа зөрчлийг дахин гаргуулахгүй байхад анхааран ажиллах болно.



Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
Удирдлага
Дарга
Санжмятав Энхбаяр
2024.05.09 11:30



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Денверийн гудамж 13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190, Утас: (976) 7007 0109
Цахим шуудан: info@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2024.05.09 № 2/950
танай _____ -ны № _____ -т
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллах болно.



Сүхбаатар Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар
Удирдлага
Засаг Даргын Орлогч
Мөнхмагнай Алтангэрэл
2024.05.09 15:26



**НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Өөрийн байр, Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 0109
Цахим хуудас: www.shd.mn

2024.05.09 № 03/1313
танай 2024.05.03 -ны № 776 -т
Хариу хүргүүлэх тухай

Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Зураг төсөв боловсруулах ажлын хувьд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар ХАА-ны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад гүйцэтгэгчийн ажлын ачаалал их болдог, нэгэн зэрэг олон зургийн ажил гүйцэтгэхэд хугацаа их шаардагдаж, ТАХ-ний хэрэгжих хугацаа удаашрах, тооцоолол дутуу хийгдэх зэрэг эрсдэл бодит байдалд үүсдэг болно.

Гүйцэтгэлийн аудитын тайланд дурьдсан асуудлуудад цаашид анхаарч ажиллах болно.



Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газар ТБАГУТҮГ
Удирдлага
Тамгын газрын дарга
Долгор Төмөрбаатар
2024.05.09 11:25



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж 16, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7777 1992
Цахим шуудан: info@chingeltai.gov.mn
Цахим хуудас: www.chingeltai.gov.mn

2024.05.07 № 3/1133
танай _____ -ны № _____ -т
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 776 тоот албан бичгээр ирүүлсэн НТАГ-2024/18-11ШТА-ГА дугаар бүхий Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд сэдэвт аудитын тайланг уншиж танилцлаа.

Дээрх аудитын тайлантай холбоотой санал, хүсэлт байхгүй болно.



Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Дарга
Жавзий Лхагвасүрэн
2024.05.07 14:40



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Замчдын гудамж 3, 27 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16052
Утас: (976) 7012 0320
Цахим шуудан: info@bgd.mn
Цахим хуудас: www.bgd.mn

2024.05.10	№	02/972
танай	2024.05.03	-ны № 776 -т

「НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ」

Дүүргийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Тайланд өгөх саналгүй болно.



Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар
Тамгын газрын дарга
Тамгын газрын дарга
Батболд МӨНГӨНХУЯГ
2024.05.10 15:37

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Дүүргүүдийн ЗД болон ЗДТГ-аас аудитын тайлангийн төсөлтэй танилцаж Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд саналаа ирүүлж, цаашид аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллахаа илэрхийлсэн.

ХАВСРАЛТ

Хавсралт 1.

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй ТАХ

(сая.төг)

№	Дүүрэг	ТАХ-ний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Хугацаа		2023 онд санхүүжиг дэх дүн
					Эхлэх	Дуусах	
1	БГД	Гэрлэх ёслолын ордны номын сангийн засвар, тохижилт	Тохижилт	176.8	2023	2023	176.8
2	БГД	Хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ хийх ажил	Тохижилт	100.0	2023	2023	100.0
